



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
НАМ/ЭВСЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ДҮГНЭЛТ
ГАРГАСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

Сайншанд



НАМ/ЭВСЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ДҮГНЭЛТ ГАРГАСАН АЖЛЫН ТАЙЛАН

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газраас Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох 10 нам, 1 эвслээс нийт 55 сонгуулийн мөрийн хөтөлбөр ирүүлсэн.

Хүснэгт 1. Нам эвслээс ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн тоо

№	Нам, эвслийн нэр	Аймгийн ИТХ-д оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөр	Сумдын ИТХ-д оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөр
1	Монгол ардын нам	1	14
2	Ардчилсан нам	1	14
3	Их нам	1	14
4	Хүн нам	1	2
5	Шинэ нам	1	-
6	Үнэн ба зөв нам	1	-
7	Иргэний зориг ногоон нам	1	-
8	Үндэсний эвсэл	1	-
9	Сайн иргэдийн ардчилсан нам	1	-
10	Монголын хүний төлөө нам	1	-
11	Хөгжлийн хөтөлбөр нам	1	-
	Нийт	11	44

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10, дахь хэсгийг тус тус үндэслэн Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох 11 нам, эвслийн “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-т аудит хийхэд дараах 3 намын 5 сонгуулийн мөрийн хөтөлбөр нийцтэй дүгнэлт гаргасан. Үүнд:

- Хүн нам-3
- Иргэний зориг ногоон нам-1
- Хөгжлийн хөтөлбөр нам-1

Харин 8 нам эвслийн 50 сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд нийцээгүй, эдийн засгийн үндэслэл тооцоо судалгаагүй зорилт, арга хэмжээ тусгасан нь хууль тогтоомжийн холбогдох шаардлагад нийцсэн гэх дүгнэлт гаргах боломжгүй байсан.



Хүснэгт 2. Нийцээгүй тухай урьдчилсан дүгнэлт гарган хүргүүлсэн мөрийн хөтөлбөрийн тоо

№	Нам, эвслийн нэр	Аймгийн ИТХ-д оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөр	Сумдын ИТХ-д оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөр
1	Монгол ардын нам	1	14
2	Ардчилсан нам	1	14
3	Их нам	1	14
4	Шинэ нам	1	-
5	Үнэн ба зөв нам	1	-
6	Үндэсний эвсэл	1	-
7	Сайн иргэдийн ардчилсан нам	1	-
8	Монголын хүний төлөө нам	1	-
	Нийт	8	42

Урьдчилсан дүгнэлтийн нэгдүгээр хавсралтаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтад нийцээгүй зорилт, арга хэмжээний жагсаалтыг, хоёрдугаар хавсралтаар “дунд, урт хугацааны хөгжлийн бодлого”...-д нийцээгүй зорилт, арга хэмжээний жагсаалтыг, гуравдугаар хавсралтаар санхүүжилтийн эх үүсвэр, зардлын дүн шаардлагатай боловч тодорхойгүй байсан зорилт, арга хэмжээний жагсаалтыг хүргүүлсэн болно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд “тав” хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулах зохицуулалттай болохыг мэдэгдсэн.

НЭГ. УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТИЙН ДАГУУ ШИНЭЧЛЭН ИРҮҮЛСЭН МӨРИЙН ХӨТӨЛБӨР НЬ СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд “тав” хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн материалыг үндэслэн дараахь 4 намын 46 сонгуулийн мөрийн хөтөлбөр нийцсэн дүгнэлт гаргасан. Үүнд

- Монгол ардын нам
- Ардчилсан нам
- Иргэний хөдөлгөөний нам
- Үнэн ба зөв нам

Харин Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд “тав” хоногийн дотор зөрчлийг арилгаагүй 4 намын мөрийн хөтөлбөрт нийцээгүй дүгнэлт гаргасан. Үүнд:



- Шинэ нам
- Үндэсний эвсэл
- Сайн иргэдийн ардчилсан нам
- Монголын хүний төлөө нам

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 2024 оны ээлжит сонгуульд оролцох 8 нам, эвсэл нь Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газраас хүргүүлсэн урьдчилсан дүгнэлтэд үндэслэн дараах байдлаар нэмэлт тайлбар, тодруулга болон шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааг шинэчлэн ирүүлсэн байна. Тухайлбал:

Нам, эвслээс ирүүлсэн: Төрийн аудитын байгууллагын дүгнэлтийн нэгдүгээр хавсралтын **Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт нийцээгүй жагсаалт**-ын дагуу засварласан зорилт, арга хэмжээ, түүний тооцоолол-ын нэгтгэл судалгааг **"Хавсралт 1"**-ээр үзүүлэв.

Ажлын хэсгийн тайлбар 1. Дүгнэлтээр нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн 7 арга хэмжээ болон хуулийн заалтын агуулга, арга хэмжээний томъёололд засвар хийж ирүүлэхээр хүргүүлсэн. "Урьдчилсан дүгнэлт"-ийн дагуу саналыг хүлээн авч зорилт, арга хэмжээг хуульд нийцсэн байдлаар агуулгын болон хэрэгжилтийг хангах арга замыг тодорхойлсон өөрчлөлт хийж ирүүлсэн байна. Хууль эрх зүйн зохицуулалт хийснээр бодлогын шийдвэр гаргаснаар хэрэгжүүлнэ гэсэн тул нийцлийг хангах боломжтой гэж үзэв.

Нам, эвслээс ирүүлсэн: Төрийн аудитын байгууллагын дүгнэлтийн хоёрдугаар хавсралтын **"Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого"-д нийцээгүй зорилт, арга хэмжээний жагсаалт**-ын дагуу засварласан заалтуудыг **"Хавсралт 1"**-оор үзүүлэв.

Ажлын хэсгийн тайлбар 2. "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030", урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн шинэчлэн ирүүлсэн нэмэлт тайлбар, тодруулгыг "хангалттай/хууль тогтоомжийн шаардлага/нийцлийг" хангасан гэж үзэн мөрийн хөтөлбөрт хэвээр үлдэх боломжтой гэж үзэв.

Нам, эвслээс ирүүлсэн: Төрийн аудитын байгууллагын дүгнэлтийн гуравдугаар хавсралтын дагуу **"Санхүүжилтийн эх үүсвэр, зардлын дүн шаардлагатай зорилт, арга хэмжээний жагсаалт"**-ын нэмэлт тайлбар тодруулгын нэгтгэл судалгааг **"Хавсралт 1"**-ээр үзүүлэв.

Ажлын хэсгийн тайлбар 3. Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн санхүүжилтийн эх үүсвэрийг **Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт** заасны дагуу санхүүгийн эх үүсвэр болон зардлыг шинэчлэн ирүүлсэн байна.

Нийт 5 намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тодруулга шаардсан нийт 764 зорилт, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодотгохоор хүргүүлснээс 1 нам 3 зорилт арга хэмжээний эх үүсвэрийг тооцож ирүүлээгүй, 4 нам 761 зорилт арга, хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодотгож ирүүлсэн байна.



Хүснэгт 3. Эх үүсвэрийн ангилал

Хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэр	Шаардагдах санхүүгийн эх үүсвэр
А	1
Улс, орон нутгийн төсөв / хуулийн тогтоомжийн заалт /	3,361,365.2
Гадаадын зээл / хуулийн тогтоомжийн заалт /	12,762.0
Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт / хуулийн тогтоомжийн заалт /	23,564.0
Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас / хуулийн тогтоомжийн заалт /	3.0
Концессын гэрээ / хуулийн тогтоомжийн заалт /	104,313.4
Бусад эх үүсвэр, тусламж /хуулийн тогтоомжийн заалт/	325,697.4
Нийт дүн	3,827,705.0
Б	
Улс, орон нутгийн төсвийн дүн нийт дүнд эзлэх хэмжээ	88.0
Бусад эх үүсвэр буюу хэсгийн дүн нийт дүнд эзлэх хэмжээ /2+3+4+5+6/	12.0

Нам/эвслийн мөрийн хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу ангилан авч үзвэл нийт эх үүсвэрийн 88.0 хувийг улс, орон нутгийн төсвөөс, 12.0 хувийг бусад эх үүсвэр /Гадаадын зээл+Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт+Засгийн газрын гадаад дотоод үнэт цаас+Концессын гэрээ+Бусад эх үүсвэр, тусламж/-ээс санхүүжүүлэхээр байна.

Дээр үзүүлсэн “бусад эх үүсвэр” буюу нийт 466,339.8 сая төгрөгийн 3 хувийг гадаад зээлээр, 5 хувийг гадаад, дотоод хөрөнгө оруулалтад тулгуурласан, 0.001 хувийг Засгийн газрын үнэт цаас гаргах хэлбэрээр, 22 хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр, 70 хувийг бусад эх үүсвэр, тусламжийн хэлбэрээр санхүүжүүлнэ гэсэн байна. (Хүснэгт 3-т үзүүлэв)

Нам/эвслийн мөрийн хөтөлбөрийг санхүүжүүлэх үүсвэрийн дүн нь “Улсын төсвийн нийт зарлага”-ын дүнгээс бага буюу улс, орон нутгийн төсвийн эх үүсвэр нь төсвийн үзүүлэлтийн хязгаар болон төсөөллийн үзүүлэлтийн хэмжээнд байна.

АЖЛЫН ХЭСГИЙН САНАЛ ДҮГНЭЛТ

- Ажлын хэсэг “Урьдчилсан дүгнэлт” гаргах ажлын хүрээнд хөтөлбөрт шаардлагатай зардал, санхүүжилтийн эх үүсвэрийг тодотгох 764, хэрэгжүүлэх үндэслэл, арга замыг тодруулах 126, сонгуулийн тухай хуулийн заалттай холбоотой 300 буюу уг хуулийн заалтын агуулга давхардаж байгаа 7, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай холбогдох 1 багц зорилт, арга хэмжээний талаар тайлбар санал авч, нийцэлтэй байдлыг хангуулав. (Энэхүү ажлын баримтын хавсралт 1-т үзүүлэв)
- Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор 10 нам 1 эвсэл сонгуулийн мөрийн хөтөлбөр ирүүлснээс 7 намын мөрийн хөтөлбөрт нийцсэн, 3 нам, 1 эвсэлд нийцээгүй дүгнэлт өгсөн
- Нам/эвслийн мөрийн хөтөлбөрийг санхүүжүүлэх үүсвэрийн дүн нь “Улсын төсвийн нийт зарлага”-ын дүнгээс бага буюу улс, орон нутгийн төсвийн эх үүсвэр нь төсвийн үзүүлэлтийн хязгаар болон төсөөллийн үзүүлэлтийн хэмжээнд байна.
- Гэвч өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын болзошгүй үр дагавар, үр нөлөө нь мөрийн хөтөлбөртөө дэвшүүлсэн төсвийн



хөрөнгөөр хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалтын амлалт, хуримтлал үүсгэх болон шинээр хэрэгжүүлэх нийгмийн халамжийн чиглэлээрх зорилт, арга хэмжээ нь чирэгч хүчин зүйл мэт ажиглагдаж болох ч төсөв санхүүгийн хүндрэл үүсэж болзошгүй байна.

- Мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн төсвийн тэнцлийг сайжруулж, хуримтлал үүсгэх бодлогын болон эрсдэлээс сэргийлж эдийн засаг өсөлттэй үед төсвийг хумих, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлэх, зардлыг хэмнэнэ гэсэн зорилт, арга хэмжээг тууштай хэрэгжүүлбэл төсвийн тухай хууль тогтоомжтой нийцнэ гэж үзэв

ТАНИЛЦСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

БОЛОВСРУУЛСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

У.ОЮУНТҮЛХҮҮР

